



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/372

Мөрөн сум

Бөхийн цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.5, дөрөвдүгээр бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жил, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 93 жилийн ойн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 бөхөөс Тав давсан Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын харьяат сумын заан Ганбаатар овогтой Өнөрбатад аймгийн начин цол олгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, баяр наадам зохион байгуулах хорооны дарга (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ